



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/199

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын хурлын тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 03 тоот албан даалгавар, Засгийн газрын Хөдөө аж ахуйн бэлтгэл хангах тухай 2020 оны 69 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцөд 2020-2021 оны тэжээл бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа Ж.Батхүүд гэрээний дагуу 4 060 000 төгрөг /дөрвөн сая жаран мянган/-ийг олгосугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 4 060 000 төгрөгийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ